



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар A/112

Алтай хот

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 115 дугаар тогтоолоор баталсан "Мал хамгаалах эргэлтийн сангийн журам"-ын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал хамгаалах эргэлтийн сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулан, хөрөнгө бүрдүүлэх, зарцуулахад хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.


Зөвлөлийн дарга:	Г.Чинбат	(Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:	Л.Хаш-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	С.Баярмаа	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, хөдөө аж ахуйн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	Т.Галсан	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч)
	Г.Ууганбаатар	(Иргэний төлөөлөл)
Нарийн бичгийн дарга:	С.Эрдэнэ-Очир	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн албаны дарга)

2. Мал хамгаалах эргэлтийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу зарцуулж, журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөлийн дарга (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

3. Мал хамгаалах эргэлтийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг жил бүр Засаг даргын Удирдлагын зөвлөлд тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга (Г.Чинбат)-д даалгасугай.

4. Тус захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/112 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР